

2017 оны жүдо бөхийн өсвөр үеийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн 03-р сарын 30-аас 04-р сарын 03-ны өдрүүдэд Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газрын зааланд зохион байгуулагдаж, тэмцээнд Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод аймгийн 270 гаруй тамирчид хурд хүчээ сорин өрсөлдөж байна. Говьсүмбэр аймгаас 2 дасгалжуулагч, 20 тамирчин хамт оролцож Эрэгтэй -27 кг жинд Д.Эрдэнэбат түрүүлж алтан медаль, +78 кг жинд Б.Цоож мөнгөн медаль хүртлээ.



2017 оны Футзалын хөвгүүдийн 15,17 насны ангиллын өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх олгох бүсийн тэмцээнийн 2017 оны 01 сарын 4-ноос 6-ны хүртэл Говьсүмбэр аймагт зохион байгуулагдлаа. Тэмцээнд Хэнтий аймаг, Дорноговь аймаг, Сүхбаатар аймаг, Дорнод аймаг, Говьсүмбэр аймаг гэсэн 5 аймгийн 8 багийн 90 гаруй тамирчид оролцлоо. Тэмцээний U-15 насны ангилалд 1-р байранд Ж.Цэнджав дасгалжуулагчтай Ө.Ганбаяр ахлагчтай Дорнод аймаг, 2-р байранд Б.Буянтогтох дасгалжуулагчтай Б.Эрдэнэбилэг ахлагчтай Говьсүмбэр аймаг, 3-р байранд Э.Соднос дасгалжуулагчтай Т.Бат-эрдэнэ ахлагчтай Сүхбаатар аймгийн баг тамирчид оролцсон. U-17 насны ангилалд 1-р байранд Ж.Цэнджав дасгалжуулагчтай Б.Ганбаяр ахлагчтай Дорнод аймаг, 2-р байранд Б.Буянтогтох дасгалжуулагчтай Б.Эрдэнэ-уул ахлагчтай Говьсүмбэр аймаг, 3-р байранд Б.Эрдэнэ дасгалжуулагчтай О.Алтансүх алхагчтай Дорноговь аймгийн баг тамирчид орлоо.



Монголын хөлбөмбөгийн холбооны идэрчүүдийн U-15, U-17 насны 2017 оны улсын аварга шалгаруулах тэмцээний урьдчилсан шат болох зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн 04 сарын 21-28-ны өдрүүдэд хөлбөмбөгийн талбайд боллоо. Тэмцээний нээлтэнд аймгийн Засаг даргын орлогч Ш.Билэггүмбэрэл, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Содном, аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга МУГДасгалжуулагч Л.Цэдэнсодном, Монголын хөлбөмбөгийн холбооны мэргэжилтэн, тэмцээний ерөнхий шүүгч Ч.Мягмарсүрэн нар оролцож тэмцээнд оролцогч баг тамирчдад мэндчилгээ дэвшүүлж амжилт хүслээ.

Зүүн бүсийн идэрчүүдийн аварга шалгаруулах тэмцээнд н.Гүнурсгал дасгалжуулагчтай Дорноговь аймгийн U-15, U-17 насны ангиллын баг тамирчид, Ц.Өсөхбаяр дасгалжуулагчтай Сүхбаатар аймгийн U-15 насны ангиллын баг тамирчид, н.Батсайхан дасгалжуулагчтай Өмнөговь аймгийн U-15 насны баг тамирчид, Ө.Одбаяр дасгалжуулагчтай Хэнтий аймгийн U-15 насны ангиллын баг тамирчид, н.Маргад-Эрдэнэ дасгалжуулагчтай Дорнод аймгийн U-15 насны баг тамирчид, Б.Буянтогтох дасгалжуулагчтай Говьсүмбэр аймгийн U-15, U-17 насны баг тамирчдын зургаан аймгийн 8 багийн дунд явагдаж аваргуудаа тодруулсан.

U-15 насны ангилалд 1-р байранд Б.Буянтогтох дасгалжуулагчтай Говьсүмбэр аймаг, 2-р байранд н.Гүн-урсгал дасгалжуулагчтай Дорноговь аймгийн баг тамирчид орсон. U-17 насны ангилалд 1-р байранд Б.Буянтогтох дасгалжуулагчтай Говьсүмбэр аймаг, 2-р байранд н.Гүн-урсгал дасгалжуулагчтай Дорноговь аймаг, 3-р байранд Ц.Өсөхбаяр дасгалжуулагчтай Сүхбаатар аймгийн баг тамирчид орсон. Говьсүмбэр аймгийн U-15, U-17 насны ангилалын баг тамирчид улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авлаа.







Сүхбаатар аймгийн харъяат, боксын спортын олон улсын хэмжээний мастер Борын Ганбаатарын нэрэмжит олон хотын нээлттэй тэмцээн 2017 оны 05 сарын 11-14-ны Сүхбаатар аймагт амжилттай зохион байгуулагдсан. Энэхүү тэмцээнд ОУХМ Л.Зоригтбаатар дасгалжуулагчтай Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Шивээ-Овоо ХК-ний харъяа спортын "Хаялга " клубын баг тамирчид амжилттай оролцож хөвгүүдийн 40кг жинд Ш.Тэмүүлэн алтан медаль, 46кг жинд Б.Отгонбаяр хүрэл медаль, охидын 50кг жинд Б.Бямбацэрэн хүрэл медаль хүртсэн.





2017 оны Идэрчүүдийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 17-18-ний өдрүүдэд Хэнтий аймагт болж өндөрлөлөө. Тус тэмцээнд зүүн бүсийн 5 аймгийн 150 гаруй баг тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс МУГД Л.Цэдэнсодном, Б.Баярмаа дасгалжуулагч нартай манай аймгийн эмэгтэй баг түрүүлж Алтан медаль, эрэгтэй баг гуравдугаар байранд орж хүрэл медаль авч багийн нийлбэр дүнгээр ДЭД байранд орсон.

Тэмцээний “Шилдэг тэгш тоглогч”-оор Сүхбаатарын Будсүрэн, “Шилдэг хамгаалагч”-аар Эрдэнэ-Очирын Ундрахбаяр нар шалгарсан байна.



Боксын 2017 оны насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн 01 сарын оролцож байгаа Хаялага спорт клубын тамирчид маань 2 хүрэл медаль хүртлээ. 81 кг-ын жинд Г.Мандахтер +91 кг-ын жинд ОУХМ Л.Зоригтбаатар нар хүрэл медаль хүртсэн байна.





2017 оны Өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээн 2017 оны 03 сарын 23-26-ны өдрүүдэд Оч клубт амжилттай явагдаж өндөрлөсөн байна. Манай аймгаас 12 наснаас доош, 13-15 насны ангилалд нийт 16 хүүхэд оролцож Г.Сэлэнгэмөрөн 12 наснаас доош насанд ХҮРЭЛ медаль, 13-15 насны багийн төрөлд МӨНГӨН медаль, нас ахиж 16-18 насны ангилалд МӨНГӨН медаль, Холимог хосийн төрөлд АЛТАН медаль, Д.Нямбаяр 12 наснаас доош ганцаарчилсан төрөлд АЛТАН медаль, багийн төрөлд АЛТАН медаль авсан байна. Б.Тамир ахлагчтай 12 наснаас доош ангилалд МӨНГӨН медаль, 12 наснаас доош эрэгтэй төрөлд Г.Наранбаяр ХҮРЭЛ медаль хүртсэн бол тэмцээний шилдэг тамирчнаар Д.Нямбаяр, хамгийн олон медаль хүртсэн тамирчнаар Г.Сэлэнгэмөрөн нар шалгарсан байна.Тэмцээний Шилдэг дасгалжуулагчаар Сансар хайрхан клубын дасгалжуулагч багш Д.Ганбаатарыг тодруулсан бөгөөд Олон улсын тэмцээнд оролцох эрхийг тамирчин Г.Сэлэнгэмөрөн, Э.Мөнхдөл нарт олгожээ.





Ази тивийн хошой аварга, Монголын боксын спортын ууган гавьяат тамирчин Х.Алтанхуяг багшын нэрэмжит 2017-оны Залуучуудын улсын аварга шалгаруулах боксын тэмцээн 2017 оны 02 сарын 7-12-ны өдрүүд Улаанбаатар хотноо 34 байгууллагын 230 гаруй баг тамирчид оролцож, амжилттай зохион байгуулагдлаа.

Тэмцээнд Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Шивээ-Овоо ХК-ний дэргэдэх ОУХМ Л.Зоригтбаатар дасгалжуулагч "Хаялага спорт" клубын баг тамирчид амжилттай оролцож 60кг жинд тамирчин З.Дөлгөөн хүрэл медаль хүртлээ.



2017 оны 3 дугаар сарын 25 – 4 дүгээр сарын 2-ны хооронд Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд зохион байгуулагдсан Боксын өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд Хаялага спорт клубын ОУХМ Л.Зоригтбаатар дасгалжуулагчтай Д.Номиндарь 46 кг жинд хүрэл медаль, Ц.Эрдэм 52 кг жинд хүрэл медаль хүртсэн.





2017 оны Идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээн 3 дугаар сарын 27-ноос 4 дүгээр сарын 3-нд Баянхонгор аймагт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тус тэмцээнд охид-16, хөвгүүдийн-16 баг хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдөж аваргуудаа тодрууллаа. Манай охидын баг МУГД Л.Цэдэнсодном, Б.Баярмаа нарын удирдлага дор оролцон хүрэл медалийн болзол хангаж, С.Будсүрэн шилдэг давуулагчаар, Ч.Номин-Эрдэнэ шилдэг холбогчоор шалгарсан байна. Мөн намар зохион байгуулагдах Супер-8 шигшээ тэмцээнд оролцох эрхийг авсан.



Сагсан бөмбөгийн анхны шигшээ багийн тоглогч, сагсан бөмбөгийн спортын ууган мастер, С.Чоён багшийн нэрэмжит U18 насны "Идэрчүүд"-ийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2017 оны 03 сард Б.Баттогтох багшийн удирдлага дор оролцсон охидын баг хүрэл медаль хүртсэн.



"Гацуурт" ХХК-ийн нэрэмжит даамны 2017 оны өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээний охидын 14-16 насны ангилалын түргэн тоглолтын төрөлд аймгийн тамирчин С.Сарантуяа мөнгөн медаль хүртлээ.



Монголын суугаа волейболын 2017 оны Улсын аварга шалгаруулах тэмцээн нь 04 сарын 24,25-нд Улаанбаатар хотод зохион байгуулагдлаа. Тэмцээнд Говьсүмбэр аймгаас эрэгтэй, эмэгтэй баг, дасгалжуулагч нийт 14 тамирчин оролцсон. Говьсүмбэр аймгийн эмэгтэй баг тамирчид 1-р байр, Говь-Алтай аймаг хоёрдугаар байр, Архангай аймаг гуравдугаар орсон.





Усан спортын өсвөр үе, идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2017 оны 5 сарын 12-14 ны өдрүүдэд Эрдэнэт хотын “Хангарьд” цогцолборт зохиогдлоо. Тэмцээнд 16 багийн 200 гаруй тамирчид оролцлоо. Говьсүмбэр аймгаас Б.Батмөнх дасгалжуулагч, 14-н тамирчинтай амжилттай оролцлоо.

Тэмцээний 9-11 насны ангилалд уралдсан Э.Есүй-Эрдэнэ далайн гахай сэлэлтээр 100м зайд мөнгөн медаль, Э.Халиун мэлхий сэлэлтээр 50,100м тус тус хүрэл медаль А.Түвшинбаяр далайн гахай сэлэлтээр 100м зайд хүрэл медаль Ш.Уянга далайн гахай 50м зайд хүрэл медаль, Б.Баяржавхлан өвөр 50м зайд хүрэл медаль, далайн гахай 50м зайд мөнгөн медаль, О.Идэр далайн гахай 100м зайд мөнгөн медаль, мэлхий 100м, 200м зайд тус тус хүрэл медаль,

О.Элбэрэл өвөр 1500м зайд хүрэл медаль хүртсэн. нийт 4 мөнгө, 7 хүрэл медаль хүртсэн. Багийн нэгдсэн дүнгээр 7-р байранд орсон.



Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 96 жилийн ой, Монгол хүн сансарт ниссэний 36 жилийн ойг тохиолдуулан аймгийн Цэргийн штаб, хөнгөн атлетикийн холбоо хамтран Кросс гүйлтийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг нээлттэйгээр зохион байгууллаа. Тэмцээнд 4 насны ангилалд 73 тамирчин өрсөлдөж аваргуудаа тодрууллаа. Эрэгтэйчүүдийн 16-29 насны ангилалд Алдар спорт хорооны тамирчин Н.Адъяахүү тэргүүлсэн бол 30-аас дээш насны ангилалд аймгийн Онцгой байдлын хэлтсийн тамирчин Д.Ариунжаргал, эмэгтэйчүүдийн 16-29 насны ангилалд Алдар спорт хорооны тамирчин Н.Дулам, эмэгтэйчүүдийн 30-аас дээш насны ангилалд Усан спорт, сургалтын төвийн тамирчин А.Оюун-Эрдэнэ нар шалгарсан байна.



Цагаан сарын нэрэмжит багийн харвааны шалгаруулах тэмцээнийг 2017 оны 03 сарын 26-нд БТСГ-ын спорт зааланд зохион байгуулагдлаа. Тэмцээнд Дорноговь аймгийн Айраг сум, Даланжаргалан сум, Налайх дүүрэг, Багахангай дүүрэг, Дундговь аймгийн Баянжаргалан сум, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум, Говьсүмбэр аймгийн нийт 9 багийн 144 тамирчид оролцлоо. Тэмцээний 1-р байранд Отгонбаяр ахлагчтай Дорноговь аймаг, 2-р байранд Амгаланбаатар ахлагчтай Дорноговь аймаг, 3-р байранд Ал танхуяг ахлагчтай Говьсүмбэр аймгийн баг тамирчид орлоо.





Шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойд зориулсан барилдаанд Ховд аймгийн Буянт сумын харъяат, “Од” группын бөх аймгийн арслан Оргихын Хангай түрүүлж, Төв аймгийн Баяндэлгэр сумын харъяат, “Багануур” ХК-ийн бөх улсын начин Чулуунбаатарын Батчулуун үзүүрлэж, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харъяат, “Борхойн өргөө” ХХК-ийн бөх аймгийн арслан Төмөрбаатарын Пүрэвсүрэн, Сүмбэр сумын харъяат, Ус цаг уур орчны шинжилгээний газрын бөх аймгийн арслан Батнасангийн Үүрцайх нар шөвгөрсөн. Мөн аймгийн арслан Б.Үүрцайх уран барилдааны тусгай шагнал хүртлээ.



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 17 дугаар жарны “Алтан унжлагат” хэмээх гал тахиа жилийн сар шинийн баярт зориулсан аймаг цэргийн цолтой хүчит бөхийн барилдааныг өдөөдөр зохион байгууллаа.

Барилдаанд аймгийн арслан Д.Түмэнжаргал, Б.Гончигтавхай, Б.Үүрцайх, Э.Мөнхбаатар тэргүүтэй аймаг цэргийн цолтой хүчит 32 бөх уран мэх, ухаан бодол бяр хүчийг үзэн барилдаа. Мөн барилдааны үеэр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Г.Батзам, ИТХ-ын нарийн бичгийн дарга Ж.Оюунбилэг, аймгийн Бөхийн холбооны тэргүүн Ж.Насанбат нар залуу цагтаа үзэгч түмнээ баясган барилдаж явсан аймгийн арслан Б.Дагвадорж, М.Батсуурь, н.Бямбасүрэн аймгийн заан Х.Лувсанцэрэн зэрэг ахмад бөхчүүдэд хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардууллаа. Барилдаанд аймгийн арслан Б.Гончигтавхай түрүүлж аймгийн арслан Э.Мөнхбаатар үзүүрлэж үзэгч түмнээ баясгалаа.



Говийн бүсийн цагдаагийн байгууллагуудын аварга шалгаруулах Сагс, гар бөмбөгийн тэмцээн энэ сарын 9-11-ний өдрүүдэд Говьсүмбэр аймагт болж, аваргуудаа тодруулжээ.

Тэмцээнд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймаг дахь Цагдаагийн газар, Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар, мөн аймгийн Цогтцэций сум дахь Сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчид оролцож, авхаалж, самбаагаа сорьсон байна.

Сагсан бөмбөгийн тэмцээний эрэгтэй төрлийн тэргүүн байрт Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтсийн баг, дэд байрт Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын баг, эмэгтэй төрөлд Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын баг тэргүүн байр, Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын баг дэд байр эзэлжээ. Харин гар бөмбөгийн тэмцээний эрэгтэй, эмэгтэй төрөл тус бүрт Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын баг тэргүүлж, Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын баг дэд байрт шалгарчээ.

Тэмцээний дүнг нэгтгэхэд Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын баг тэргүүлж, говийн бүсийн аварга болсон байна.





Аймгийн аварга шалгаруулах өсвөрийн шатарчдын тэмцээн 01 сарын 20-21-ны өдрүүдэд 2-р сургуулийн байранд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд аймгийн хэмжээний 5-н сургуулийн 71 тамирчин 6 насны ангилалаар өрсөлдөж нэгдсэн дүнгээр 1-р байранд 2-р сургууль, 2-р байранд 1-р сургууль, 3-р байранд 5-р сургуулийн баг тамирчид орсон.



Өсвөрийн үеийн жүдо бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2017 оны 03 сарын 18-нд БТСГ-ын бөхийн танхимд амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд 3 багийн 90 гаруй тамирчид 15-н жинд өрсөлдлөө.



Бидний лиг - 2017 сагсанбөмбөг, волейболын тэмцээн 2017 оны 1 дүгээр сарын 21-ны өдөр Биеийн тамир спорт газрын спорт зааланд амжилттай эхэлсэн. Тэмцээн Говьсүмбэр аймгийн ЕБС-н сургуулиуд, Шивээговь сумын Хаялага спорт клуб, Биеийн тамир спортын газрын 13-16 насны хүүхдүүдийн эрэгтэй, эмэгтэй нийт 16 баг оролцоно. Эхний ээлжийн тоглолтууд амжилттай зохион байгуулагдлаа.





Монгол Улсын Ойн тухай хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу бүх нийтээр мод тарих өдрийг жил бүр хавар, намрын улиралд уламжлал болгон зохион байгуулдаг арга хэмжээнд оролцлоо. Аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/105 тоот захирамжийн хүрээнд аймгийн хэмжээнд 2017 оны 05 сарын 02-07-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан “Мод тарих” арга хэмжээний хүрээнд оролцож 115 ширхэг мод бутыг тарьсан.



Говьсүмбэр аймгийн ахмадуудын дунд "Спортын бага наадам" спортын 3 төрлөөр 05 сарын 6,7-нд 2-р сургуулийн сургуулийн спорт зааланд амжилттай зохион байгуулагдсан. Тэмцээний ерөнхий ивээн тэтгэгчээр Татварын хэлтэсийн хамт олон ажилласан.



Шивээговь суманд 2017 оны 04 сарын 29-нд ахмадын гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулсан. тэмцээнд 5 багийн тамирчид оролцсон. Тэмцээний эхний тэмцээнд амжилттай оролцон аймгийн тэмцээнд оролцох эрх авсан.

